



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түмэнцогт Ус- Дулаан ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2024/04/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт хот
2023 он

Дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123
Аудитор: О.Барчидгүнсэн
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮМЭНЦОГТ
СУМЫН ТҮМЭНЦОГТ УС ДУЛААН ААТҮГ
ЗАХИРАЛ Э.ОТГОНТӨГС ТАНАА

2024.03.15 № 229

танай _____ - ны№ _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Түмэнцогт ус дулаан" ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Түмэнцогт ус дулаан" ААТҮГ -ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 09 дүгээр тогтоолоор байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулсан бөгөөд Сүхбаатар аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны А/16 тоот тогтоолоор үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулсан байна.

Аудитын гол асуудал

"Түмэнцогт ус дулаан" ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаар 40,600.2 мянган төгрөгийн алдагдалтай тайлагнасан. Энэ нь өмнөх оноос 90,243.2 мянган төгрөгөөр буурсан бөгөөд айл өрх, төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагын халаалт дулааны үнэ тариф өссөн, мөн үр ашиггүй зардлыг бууруулж ажилласан нь нөлөөлжээ.

Бусад асуудлын хэсэг

"Түмэнцогт ус дулаан" ААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулжээ. Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, гүйцэтгэлийг 86 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

D:/Bichig hereg/2024/tushaal

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20656748.66	31581521.99
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1886376.33	3573506.36
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,886,376.33	3,573,506.36
3121	Төгрөг	1886376.33	3573506.36
33	АВЛАГА	6,640,699.66	12,476,520.63
35	БАРАА МАТЕРИАЛ	12129672.67	15531495.00
351	Түүхий эд материал	1595880.00	6864000.00
354	Хангамжийн материал	10533792.67	8667495.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1820414830.28	1661192624.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1820414830.28	1661192624.20
392	Биет хөрөнгө	1806222830.28	1647000624.20
393	Биет бус хөрөнгө	14192000.00	14192000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1841071578.94	1692774146.18
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	449584963.67	326004072.66
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	449584963.67	326004072.66
413	Өглөг	46248973.44	65460054.61
4136	Бусад өглөг	46248973.44	65460054.61
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	16,021,363.45	24,883,693.62
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	30,227,609.99	40,576,360.99
414	Урьдчилж орсон орлого	403335990.23	260544018.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1391486615.27	1350886387.70
51	Засгийн газрын хувь оролцоо	1391486615.27	1350886387.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1277836426.90	1277836426.90
51101	Өмч: - төрийн	1,277,836,426.90	1,277,836,426.90
512	Хуримтлагдсан үр дүн	-1568105801.49	-1608706029.06
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,568,105,801.49	-1,568,105,801.49
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-40,600,227.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,681,755,989.86	1,681,755,989.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1841071578.94	1676890460.35

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	370090047.82	380862210.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	370090047.82	380862210.26
120	Нийтлэг татварын бус орлого	370090047.82	380862210.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	370090047.82	372275810.26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	370,090,047.82	372,275,810.26
120009	Бусад орлого	00.00	8,438,400.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	00.00	148,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	500933463.68	421462437.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	500933463.68	421462437.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	498993463.68	420262437.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56452053.00	57467971.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81855476.00	13980795.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88914079.02	277080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	67214058.00	648817.38
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	2100000.00
2107	Томилолт, зочны зардал	340000.00	688000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	862500.00	421186.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	172,500.00	172,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	690,000.00	89,500.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	00.00	159,186.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	203355297.66	344678586.96
211	ХҮҮ	1940000.00	1200000.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	1940000.00	1200000.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	1,940,000.00	1,200,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-130843415.86	-40600227.57
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-130843415.86	-40600227.57

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,277,836,426.90	1,681,755,989.86	-1,568,105,801.49	00.00	1,391,486,615.27
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,277,836,426.90	1,681,755,989.86	-1,568,105,801.49	0.00	1,391,486,615.27
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,277,836,426.90	1,681,755,989.86	-1,568,105,801.49	0.00	1,391,486,615.27
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,277,836,426.90	1,681,755,989.86	-1,568,105,801.49	0.00	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,277,836,426.90	1,681,755,989.86	-1,568,105,801.49	0.00	1,391,486,615.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-40,600,227.57	00.00	-40,600,227.57
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,277,836,426.90	1,681,755,989.86	-1,608,706,029.06	0.00	1,350,886,387.70

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	410567369.84	402166532.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	410567369.84	402166532.75
120	Нийтлэг татварын бус орлого	410567369.84	402166532.75
120009	Бусад орлого	00.00	8,385,800.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	00.00	393,780,732.75
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	414165216.65	399629402.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	414165216.65	399629402.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	414165216.65	399629402.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	142296667.47	135105743.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43993562.01	49215217.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88914079.02	39451698.11
2104	Хангамж, бараа материалын зардал	110580270.61	148315477.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	66,914,058.00	92,401,804.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	43,666,212.61	55,913,673.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28170262.54	27541267.12
210815	Хүүний төлбөрт төлсөн /ТӨҮГ/	1,940,000.00	1,200,000.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	26,163,462.54	14,503,942.12
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	66,800.00	11,837,325.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-3597846.81	2537130.03
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	850000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	850000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	850000.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	00.00	850,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-850000.00
14	Бусад эх үүсвэр	15000000.00	0.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	15,000,000.00	00.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	10000000.00	0.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	10,000,000.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	5000000.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1382353.19	1687130.03

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	504,023.14	1,886,376.33
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,886,373.33	3,573,506.36

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	хэмжих нэгж	2022оны Гүйцэтгэл.	2023 он төлөвлөгөө	2023 оны Гүйцэтгэл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	гкал	3.96	3.92	3.92
2	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн тоо		192.00	190.00	190.00
	-айл өрхийн тоо	ш	158.00	159.00	159.00
	-Албан байгууллагын тоо	ш	34.00	32.00	32.00
3	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн үнэ	төг	1,650.00	1,650.00	1,650.00
4	Нийт орлого	мян.төг	370,090.00	370,090.00	380,830.30
	цэвэр борлуулалт	мян.төг	370,090.00	370,090.00	380,830.30
5	Нийт зардал	мян.төг	500,933.40	450,800.00	416,638.90
	Үүнээс: удирдлагын зардал	мян.төг	343,434.30	125,600.00	114,871.80
6	Татварын өмнөх ашиг	мян.төг	(130,843.40)	(80,710.00)	(35,808.6)
7	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	(130,843.40)	(80,710.00)	(35,808.60)
8	Төсвийн төлбөр		2,420.00	2,420.00	2,420.00
9	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.35	1.26	0.94
10	Нийт авлага	мян.төг	6,640.70	5,630.00	12,444.70
11	Нийт өглөг	мян.төг	46,248.90	42,560.30	86,044.40
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	46,248.90	42,560.30	86,044.40
12	Хөрөнгө оруулалт, их засвар ТЗБАХ	мян.төг	214,000.00	87,000.00	87,000.00
13	Ажиллагсадын тоо	мян.төг	19.00	19.00	19.00
14	Цалингийн сан	мян.төг	201440.5	214500.6	201440.5
15	Нийт хөрөнгийн дүн	мян.төг	2,641,211.74	2,641,211.70	2,645,463.57
16	-эргэлтийн хөрөнгө	мян.төг	20,656.70	20,656.70	29,924.00
	үүнээс бараа материал	мян.төг	12,129.60	12,129.60	11,250.30
17	-үндсэн хөрөнгө	мян.төг	2628232.07	262832.07	2629082.07

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түмэнцогт ус дулаан ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 5 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлаас 414,185.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,212.7 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 49,462.4 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх онд дулаан үйлдвэрлэлтэй холбоотой зардлыг бүртгэснийг тайлант онд залруулж бүртгэсэн бөгөөд үр ашиггүй зардлыг бууруулжээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлжээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	-	2	-	100
Нийт дүн	2	0	2	-	100

/мянган төгрөгөөр/

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;